

**СТИВЭН БАРНЭТТ: МОНГОЛ УЛС БАЯЛАГИЙН ХАРААЛД
ӨРТӨХ ЭРСДЭЛ ӨНДӨР БАЙНА**

Олон улсын валютын сангийн ажлын хэсэг энэ сарын 14 - 20-ны өдрүүдэд манай улсад ажиллаж, Стэнд-бай хөтөлбөрийн дараах хяналтын яриа хэлэлцүүлэг хийсэн аж. Түүнчлэн ОУВС-гийн Ази, Номхон далайн бүсийн төвийн дэд захирал Стивэн Барнэттаар ахлуулсан ажлын хэсэг Монгол Улсын төр засгийн болон бусад байгууллагуудын макро эдийн засагт гарсан өөрчлөлт, бодлогын асуудлаар судалгаа хийсэн байна. Судалгааны ажилтай холбогдуулан өчигдөр ОУВС-гийн Ази, Номхон далайн бүсийн төвийн дэд захирал Стивэн Барнэтт хэвлэлийнхэнд мэдээлэл хийсэн юм. Түүнтэй уулзаж ярилцлаа.

- Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал хэр байна вэ. Та бүхний зүгээс ямар үнэлэлт дүгнэлтийг гаргасан бэ?

- Дэлхий дахинд нүүрлэсэн эдийн засгийн хямралаас Монгол Улс маш хурдан гарч, сэргэж чадсан гэсэн дүгнэлтийг хийж байгаа. Өнгөрсөн онд ОУВС-тай хамтран хэрэгжүүлж байсан Стэнд-бай хөтөлбөр дуусгавар болсон. Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газраас макро эдийн засгийн ухаалаг зөв бодлого барьж ажиллаж байсны үр дүн. Цаашид хамтын ажиллагаагаа улам идэвхижүүлэх болно. Цаашид Монгол Улсад нүүрсний үйлдвэрлэл өсч байна. Түүнчлэн уул уурхайн хоёр том төсөл удахгүй эдийн засгийн эргэлтэд орно. Манай ажлын хэсэг эрх баригчидтай эдийн засгийн төлөв байдал, бодлогын сорилт бэрхшээлийн талаар илэн далангүй яриа хэлэлцүүлэг хийсэн. Эрдэс баялагийн арвин их нөөц баялагаа эдийн засгийн эргэлтэд оруулсанаар Монгол Улсыг гэрэлт ирээдүй хүлээж байгаа гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Гэхдээ бидний зүгээс ойрын хугацаанд эдийн засгийн төлөв байдлыг доройтуулж болзошгүй томоохон эрсдэлүүд байна гэж үзэж байгаа. Тухайлбал, эдийн засгийн хэт халалт явагдаж байна. Инфляци аль хэдийн өндөр төвшинд очсон байна. Цаашид ч нэмэгдэх төлөв ажиглагдаж байгаа. Энэ нь ядуу, эмзэг бүлгийнхэнд хүнд дарамт болж, Монгол Улсын хувийн хэвшлийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадварыг доройтуулж магадгүй. Макро эдийн засгийн бодлогууд хямралын үеэр ноёрхож байсан тэлэлт агшилтын чиг шугам руу ороод байна. Түүнчлэн макро эдийн засгийн тогтвортой бус байдал нь дэлхийн эдийн засгийн төлөв байдал доройтсонтой давхцаж байгаа. Хэрвээ бараа түүхий эдийн үнэ дэлхийн зах дээр огцом унавал Монгол Улсын экспортын болоод улсын төсвийн орлого аль аль нь хүнд байдалд орно. Одоогийн өндөр инфляцийг цаашид өсөн нэмэгдэхээс сэргийлж, эмзэг байдлыг бууруулахын тулд зөв бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай. Улсын төсвийн зарлагыг хязгаарлаж, мөнгөний бодлогыг хатууруулах нь зүйтэй.

- Монгол Улсын эдийн засаг халалтын үе шатандаа байна гэж тодорхойлжээ. Эдийн засгийн халалтыг ямар үндэслэлээр гаргаж ирсэн бэ?

- Монголд эдийн засгийн өсөлт хэтэрхий өндөр байна. Энэ эргээд инфляцийг хөөрөгдөж байна. Тиймээс инфляцийн дарамт эдийн засагт улам нэмэгдсээр байна. Тэгэхээр өнөөдрөө биш алс ирээдүйгээ харсан эдийн засгийн бодлого хэрэгтэй.

- Манай улсад инфляцийн өсөлт их байгаа. Үүнд хамгийн их нөлөөлж байгаа хүчин зүйл юу байна вэ?

- Инфляцид улсын нэгдсэн төсвийн бодлого их нөлөөлж байна. 2012 оны улсын нэгдсэн төсвийн зарлага 30 гаруй хувиар огцом нэмэгдэж батлагдсан. Энэ нь халалт үүсэх гол шалтгаан болоод байна. Засгийн газраас төсвийн зарлагыг энэ оны дөрөвдүгээр улиралд багтааж ДНБ-ий 6.5 хувьтай тэнцэх хэмжээгээр нэмэх санал боловсруулаад байгаа нь маш их эрсдэл, бодлогогүй алхам болоод байна. ДНБ-ий өсөлт хоёрдугаар улиралд 17 хувиас давж, хэрэглээний барааны импорт 80 гаруй хувиар өссөн. Байдал ийм байхад төсвийн зарлагыг нэмэх нь халж буй эдийн засгийг огт шаардлагагүй үед нь улам бүр эрчимжүүлсэн алхам болно. 2012 оны төсвийн төслийн хувьд мөн зарлагыг хязгаарлах, УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд заасан хэмжээнд багтаах буюу багасгах нь зүйтэй. Төсвийн зарлагын хязгаарлалтын хүрээнд Засгийн газар нийгмийн халамжийн зорилгод тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай. Тиймээс энэ онд төсөвт тодотгол хийх шаардлагагүй гэсэн дүгнэлтийг хийж байгаа. Дараагийнх нь гадаад зах зээлтэй холбоотой. Түүнчлэн энэ цаг үетэй давхцаад дэлхийн эдийн засагт хэцүү эзэгтэй мөч ирээд байгаа. Европед улсын өрийн хямрал үүсч болзошгүй байна. Мөн АНУ-ын эдийн засаг гүн уналтад орж магадгүй үе тулгараад байгаа. Энэ бүх хүчин зүйлээс үүдэн дэлхийн эдийн засгийн төлөв байдал суларч харагдаж байгаа. Түүнчлэн Хөгжлийн банк нь төсвийн томоохон эрсдэлийг дагуулж байна гэж үзэж байгаа. Тэгэхээр Хөгжлийн банкны үйл ажиллагаа төсвөөс гадуур Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг тойрч гарах арга хэрэгслийг ашиглаж болохгүй. Мөнгөний бодлогын хүүг төв банкнаас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулсан. Цаашид ч улам нэмэгдүүлэх шаардлагатай. Он гарснаас хойш бодогын хүүгийн түвшин суурь инфляцийн өсөлтийн хурднаас хоцорч, банкны зээл өндөр хурдацаар өсөх боломжийг бүрдүүлж байна. Иймд макро эдийн засгийн зохистой байдлын арга хэмжээнүүдийг авч, зээлийн өсөлтийн хурдацыг сааруулах шаардлагатай.

- Хөгжлийн банк Засгийн газрын тусламжтайгаар олон улсын зах зээлд бонд гаргахаар төлөвлөж байгаа. Энэ нь хэр эрсдэлтэй вэ?

- Монгол Улсын дэлхийн зах зээлээс хөрөнгө татах шийдвэр гаргаж байгаа сайшаалтай хэрэг. Цаашид дэлхийн зах зээл дээр ямар үнэ өртөгтэй байршуулах боломж байна. Зээлийн зэрэглэлийг ямар түвшинд байршуулах зэрэг нь тодорхой болно. Аль болох татан төвлөрүүлсэн хөрөнгө эдийн засгийн хувьд ашигтай, эргээд эргэлтэд орох боломжтой төслийг санхүүжүүлэх нь зөв шийдвэр болно.

- Монгол Улсын эдийн засаг уул уурхайн баялагаас хамааралтай. Тиймээс “Голланд” өвчинд өртөх магадлал хэр байна вэ?

- Монгол Улс баялагын хараалд өртөх эрсдэл өндөр байна. Ийм байдалд өртсөн улс оронд ижил төстэй зүйл юу вэ гэхээр улсын төсвийн зарлага хурдацтай өссөн байдаг. Хөдөлмөрийн зах зээлд цалин хэтэрхий өндөр түвшинд хүрсэн зэрэг үзүүлэлтээс харж болно.

Б.ПҮРЭВЖАВ